



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 658

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3, 4.10 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материалын бие даасан 9,3 Гкал/ц чадалтай дулааны эх үүсвэрийн барилга гадна цахилгаан хангамж болох 10/0,4 Кв-ын 2*400кВа ХТП-ийн барилгын ажлын хүрээнд бий болсон 20 нэрийн нийт 4,822,000,000.00 (дөрвөн тэрбум найман зуун хорин хоёр сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Эрчим хүчний хөгжлийн төвийн захирал Я.Нямжаргал, Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газрын дарга Ш.Үнэнбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх,

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 1 дугаар сарын 18-ны өдрийн
65.5 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР АШИГЛАЛТАД ОРСОН
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн байршил	Хөрөнгийн нэр	Марк, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ (Төгрөг)		Ашиглагч байгууллага
						Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	
1	Улаанбаатар хот СХД-ийн 5,6-р хороо 9.3тгал/ц чадалтай дулааны эх үүсвэрийн ажил	Дулааны эх үүсвэрийн барилга 36.0 18.0x6.0м	36x1x6	м	648	1,732,177.00	1,122,450,762.00	"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ
2		Гандна хашаа	4.0x2.0	м	280	200,489.00	56,136,982.00	
3		Гадна бохир	14м3	м	1	14,598,211.00	14,598,211.00	
4		Гадна цэвэр усны цооног	100м	м	100	145,000.00	14,500,000.00	
5		Халаалтын тогоо суурилуулах 1.8мВТ	1.8мВТ	ш	2	387,749,139.00	775,498,279.00	
6		Халаалтын тогоо суурилуулах 3.5мВТ	3.5мВТ	ш	2	661,979,519.00	1,323,959,038.00	
7		Нүүрс оруулах конивер	0.5x14.0м	ш	4	92,874,080.00	371,496,321.00	
8		Нүүрс оруулах бункер	16м3	ш	4	2,463,025.00	9,852,103.00	
9		Үнс зайлуулах конивер	0.5x0.5x24.0м	ком	1	189,015,125.00	189,015,125.00	
10		Утааны төмөр яндан угсрах	ф400мм 24м	ком	7192	5,980,980.00	43,015,213.00	
11		2.5м3 эзэлхүүнтэй тэлэлтийн сав тавих	2.5м3	ш	2	7,254,492.00	14,508,984.00	
12		Халаалтын сүлжээний насос	50м3/ц х-35м	ш	2	27,069,893.00	54,139,786.00	
13		Нэмэлт усны насос	grundfox	ш	2	3,007,630.00	6,015,260.00	
14		Үнс баригч	0.4x0.4x30м	ш	4	80,258,963.00	321,035,852.00	
15		Дьмссос	500м3/ц	ш	4	26,325,896.00	105,303,584.00	
16		Гандна зам талбай	2200м2	м	2200	61,678.00	135,693,258.00	
17		Нөөц усны сав	4.0x4.0x2.0	ш	1	9,217,037.00	9,217,037.00	
18		Цахилгааны дэд ертөө барилга	9.0x6.0x4.0	ком	96	640,962.00	61,532,422.00	
19		Дэд ертөөний тоноглол	0.4кВа	ком	1	135,963,258.00	135,963,258.00	
20		Гандна тэжээлийн кабель		м	500	1,146,137.00	58,068,525.00	
						4,822,000,000.00		
НИЙТ ДҮН								(дөрвөн тэрбум найман зуун хорин хоёр сая)